# ХҮН, МАЛ, УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД БОЛОН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫГ ОДООНООС ЭХЛЭЦГЭЭЕ!

# НЯНГИЙН ЭСРЭГ ЭМ БЭЛДМЭЛИЙГ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЕ

## БИД БҮГД ТУСАЛЖ ЧАДНА!

- Нянгийн эсрэг бэлдмэлүүд, тэр дундаа антибиотик нь олон сая амь амьдралыг аварч, хүн болон мал амьтдын өвчлөлөөс үүсэх хор хохирлыг эрс бууруулж, хүн амын амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг сайжруулан, дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж байна.

- Антибиотикийн эсрэг тэсвэржилт бүхий зарим төрлийн бичил биетний тархалт болон аюултай байдал нь халдварт өвчний менежментийг хүндрүүлж байна

- Нянгийн тэсвэржилт нь хүний хөгжил болон халдварт өвчний эсрэг тэмцэхэд ихээхэн аюул учруулж байна. Эдгээр нь малын эрүүл мэнд, тавлаг байдалд нөлөөлж хүнсний үйлдвэрлэлд аюул учруулж байна. Нянгийн тэсвэржилт нь хүн, мал, ургамлын эрүүл мэнд болон эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

- Нянгийн тэсвэржилт нь хөгжиж буй орнуудад хамгийн ихээр нөлөөлж нөөц бололцоог хязгаарлаж, халдварт өвчнийг даамжруулж байна.

- Нянгийн тэсвэржилтийн эсрэг хамтын, бодит хариу үйлдлийг шаардаж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага \WHO\, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага \FAO\ болон Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгуулага \OIE\-аас 2015 онд улс орнуудад үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд зориулан олон улсын нэгдсэн төлөвлөгөөний зааварчилгааг баталсан.

- Олон улсын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах сайтуудаар орж танилцана уу:
  FAO website: www.fao.org/antimicrobial-resistance
  OIE website: www.oie.int/antimicrobial-resistance
  WHO website: www.who.int/antimicrobial-resistance





Food and Agriculture Organization of the United Nations
ORLD ORGANISATION FOR ANIMAL HEALTH
World Health Organization

# НЯНГИЙН ТЭСВЭРЖИЛТЭД БИД БҮГД ӨРТӨЖ БОЛНО!

## ХҮН, МАЛ, УРГАМАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ АЖЛЫГ ОДООНООС ЭХЛЭЦГЭЭЕ!

урьдчилан сэргийлэх | мэргэжилтний зөвлөмж | эх үүсвэр | хэрэглээ | сурталчилгаа ба боловсрол

## ҮНДЭСНИЙ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУД

### ХУУЛЬ ЭРХЗҮЙ

Нянгийн эсрэг эм бэлдмэлийг зохистой хэрэглэх, заавал мөрдөх зохицуулалттай байх
Хууль эрхзүйн хэрэгжилтийг хангах

### СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

Өвчний оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга аргачлалыг боловсруулахад санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх
Нянгийн эсрэг эм бэлдмэлийн хамаарлыг багасгах

### МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА БОЛОН БОЛОВСРОЛ

Олон нийтэд хандсан мэдээлэл сурталчилгааг өрнүүлэх, бүх талуудын боловсролыг сайжруулах

### ТАНДАЛТ БОЛОН МОНИТОРИНГ

Олон улсын стандартад тулгуурлан үндэсний хэмжээнд нянгийн тэсвэржилтийн талаар сурталчлах, нянгийн эсрэг эм бэлдмэлийн хэрэглээний тандалтын тогтолцоог сайжруулах

## ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Хүнсний гинжин хэлхээнд эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх
- Хүнсний (CODEX ALIMENTARIUS) Кодексын стандартад суурилсан эрхзүйн баримтуудыг хэрэгжүүлэх
- Эрүүл ахуйн зохистой дадал болон HACCP дүрэм журмыг нэвтрүүлсэн хангах нийлүүлэгчээс хүнсийг худалдаж авах**
- Ариун цэврийг сахих, түүхий болон болгосон хүнсийг тусад нь хадгалах, сайтар чанаж боловсруулах, хүнсийг аюулгүй температурт хадгалах, цэвэр ус, аюулгүй түүхий эдийг хэрэглэх
- Хэрэглэгчид бол хаан: хүнсний аюулгүй байдлын зөвлөмжүүдийг мөрдөж, нянгийн эсрэг эм бэлдмэлийг хариуцлагатай хэрэглэдэг үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчдийг дэмжих

## МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД*

- Мал аж ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлэх (биоаюулгүй байдал, эрүүл ахуй болон вакцинжуулалтын бүртгэл хийх)
- Нянгийн эсрэг эм бэлдмэлийг малын эмчийн оношилгоо, зааврын дагуу хэрэглэх
- Зөвхөн ДМАЭМБ-ын стандартын дагуу үйлдвэрлэгдэж, эрх бүхий эмийн сангуудаар худалдаалагдаж буй сайн чанартай нянгийн эсрэг эм бэлдмэлийг хэрэглэх
- Нянгийн эсрэг эм бэлдмэлийг малын эмчийн бичиж өгсөн тун, хэрэглэх зааврын дагуу зохистой хэрэглэх
- Малын эмч нар өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэн нянгийн тэсвэржилтийн талаар байнга анхааруулах үүрэгтэй

## УРГАМЛЫН ЭРҮҮЛ МЭНД

- Ургамлын өвчлөлийг бууруулах болон нянгийн эсрэг эм бэлдмэлийн хэрэглээг бууруулахад хөдөө аж ахуйн зохистой дадал, пестицидын нэгдсэн менежментийг нэвтрүүлэх
- Холбогдох мэргэжилтнүүдийг ургамлын өвчнийг зөв таньж, шилдэг сайн эмчилгээ хийхэд сургах
- Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг зохих эрх бүхий үйлдвэрлэгч болон хангах нийлүүлэгч байгууллагаас худалдаж авах
- Ургамал хамгааллын бүтээгдэхүүнийг зохистой хэрэглэх, антибиотикууд мөөгөнцөрийг эмчлэхгүй гэдгийг анхааруулах
- Нянгийн эсрэг эм бэлдмэлийн зохистой хэрэглээний талаар мэдээллэж байх, ургац алдагдлыг багасгах, мөнгө, эрүүл мэндээ хамгаалж чадна

## БАЙГАЛЬ ОРЧИН

- Эмийн үйлдвэрлэл, эмнэлэг, газар тариалангийн үйлдвэрлэл, хүн болон малын гаралтай хог хаягдал болон нянгийн эсрэг эм бэлдмэлийн үлдэгдлээс сэргийлэхэд хог хаягдлын менежментийн зохистой дадлыг нэвтрүүлэх
- Хаягдлын менежментийн заавар, дүрмийг дагах, хог хаягдлыг цуглуулах ажлыг хялбарчилж оромдохгүй байх
- Антибиотикийг зөвхөн баталгаатай эх үүсвэрээс хэрэглэх, хууль бус эх үүсвэрээс татгалзах
- Бохир усыг байгальд нийлүүлэхээс өмнө цэвэрлэх, дахин боловсруулах, антибиотикийг зааврын дагуу хаях, устгах
- Хүмүүсийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлаас байгаль орчноо хэрхэн хамгаалах талаар өөрийн боловсролыг дээшлүүлэх

## ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

- Мал аж ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлэх (биоаюулгүй байдал, эрүүл ахуй болон вакцинжуулалтын бүртгэл хийх) Нянгийн эсрэг эм бэлдмэлийг өсөлтийг дэмжих зорилгоор хэрэглэхгүй байх
- Нянгийн эсрэг эм бэлдмэлийг зөвхөн оношилгооны дагуу холбогдох мэргэжлийн эмчийн зааврын хэрэглэх
- Олон улсын стандартаар үйлдвэрлэгдсэн сайн чанарын нянгийн эсрэг эм бэлдмэлийг хэрэглэх
- Нянгийн эсрэг эм бэлдмэлийг малын эмчийн бичиж өгсөн тун, хэрэглэх зааврын дагуу зохистой хэрэглэх
- Хүнс үйлдвэрлэгчид өөрсдийн мэдлэг мэдээллийг баталгаатай эх сурвалжаас байнга дээшлүүлэх

## ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД

- Эрүүл ахуйн зөв дадал баримтлах
- Нянгийн эсрэг эм бэлдмэлийг эмчийн хяналтын дор зөвхөн хэрэгцээтэй үед хэрэглэх
- Баталгаагүй эмийн сангаас нянгийн эсрэг эм бэлдмэлийг худалдаж авахгүй байх, эдгээр нь магадгүй чанар, үр нөлөө муутай байдаг
- Нянгийн эсрэг эм бэлдмэлийг эмчийн заавраар хэрэглэх, эмийг хэн нэгэнтэй хуваах хэрэглэхгүй байх, өөр өвчин эмчлэхэд үлдсэн эмийг хэрэглэхгүй байх
- Гэр бүл, найз нөхөд, хамтран ажиллаж байгаа хүмүүстээ нянгийн эсрэг эм бэлдмэлийн зохистой хэрэглээний талаар мэдээлэн таниулах

***Хуурай газрын болон усны амьтны**

** Аюултай байдлын шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт